



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 176,000,000.00 (нэг зуун далан зургаан сая) төгрөгийн балансын үнэ, 144,662,222.24 (нэг зуун дөчин дөрвөн сая зургаан зуун жаран хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу "Харгуй" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. "Засгийн газрын автобааз" төрийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал Г.Чинзориг, "Харгуй" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Бат-Октябрь нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2023 оны 02 дүгээр сарын 20 өдрийн
189 дугаар тогтоолын хавсралт

**“ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Тоёото Ландкрузер-200 автомашин, улсын дугаар 9370 УНЯ	3/19/2010	176,000,000.00	144,662,222.24	31,337,777.76	“Харгуй” төрийн өмчит хувьцаат компани
Нийт дүн			176,000,000.00	144,662,222.24	31,337,777.76	